



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/284

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.2.“а”-д заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1 “Макс майнд” ХХК-ний гүйцэтгэж байгаа Хан Хэнтий чуулгын барилга угсралтын ажил удаашралтай байгаатай холбогдуулан уг барилгын ажлыг эрчимжүүлэх зорилгоор ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Чогсомжав	-Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Д.Баттулга	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Дэд бүтэц, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Ж.Ганбаатар	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
	Ж.Гантулга	-Төрийн Захиргааны Удирдлагын хэлтсийн дарга
	Л.Бат-Октябрь	-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Э. Мөнх-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Ц.Баярхүү	-Цагдаагийн газрын дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа
	Д.Баярхүү	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиглахыг Ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА